ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнхийн алба өрхийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ЗАА-2026/009//НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2026 он


Дарга,

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarH@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсувд

Утас: 99076038 Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554 Цахим хаяг: tuul9565@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан........13

4.1 Ерөнхий зүйл ........13

4.2 Материаллаг байдал ........14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........16

5. Аудитын илрүүлэлт ........16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс:7046-36-12
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn

2026.02.13 № 104

танай ______ -ны № ______ -т

"МӨНХИЙН АЛБА" ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА А.ЮМААЖАВ-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнхийн алба өрхийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөнхийн алба өрхийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мөнхийн алба өрхийн Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас 630.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 8.2 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулж, санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Мөнхийн алба өрхийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тооцоо бодоогүй, тайлан илтгэх хуудасгүй, холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвөөс 1.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 32.2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

D:\Албан бичиг\A4-2026.docx

812605193

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **113,141,048.75** | **135,588,619.36** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 47,932,003.50 | 90,306,604.38 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 47,932,003.50 | 90,306,604.38 |
| **3121** | **Төгрөг** | 47,932,003.50 | 90,306,604.38 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 47,932,003.50 | 90,306,604.38 |
| **33** | **АВЛАГА** | 26,581,062.97 | 8,192,159.30 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 26,581,062.97 | 8,192,159.30 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 38,627,982.28 | 37,089,855.68 |
| **351** | **Түүхий эд материал** | 14,640,991.90 | 8,794,264.30 |
| 35130 | Эм боох материал | 14,640,991.90 | 8,794,264.30 |
| **354** | **Хангамжийн материал** | 23,986,990.38 | 28,295,591.38 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 780,100.00 | 823,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,575,200.00 | 4,674,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,450,000.00 | 5,400,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 16,181,690.38 | 17,397,891.38 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **98,993,039.01** | **106,812,737.80** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 98,993,039.01 | 106,812,737.80 |
| **392** | **Биет хөрөнгө** | 91,877,039.01 | 99,696,737.80 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 42,003,990.00 | 42,003,990.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -18,788,899.49 | -20,685,922.25 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,950,000.00 | 41,475,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -12,959,999.84 | -14,784,166.67 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 87,981,109.69 | 93,671,121.69 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -36,248,484.80 | -57,193,823.42 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,022,664.00 | 21,147,664.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -13,621,190.55 | -13,621,190.55 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,837,850.00 | 8,837,850.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -300,000.00 | -1,153,785.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,116,000.00 | 7,116,000.00 |
| 39301 | Програм хангамж | 630,000.00 | 630,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -630,000.00 | -630,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,116,000.00 | 7,116,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **212,134,087.76** | **242,401,357.16** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **212,134,087.76** | **242,401,357.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 212,134,087.76 | 242,401,357.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 35,108,550.00 | 35,108,550.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 35,108,550.00 | 35,108,550.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 158,982,649.48 | 189,249,918.88 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 158,982,649.48 | 153,451,432.68 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 35,798,486.20 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 18,042,888.28 | 18,042,888.28 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **212,134,087.76** | **242,401,357.16** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **633,814,992.23** | **647,928,101.20** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **43,411,146.62** | **35,715,085.25** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 43,411,146.62 | 35,715,085.25 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 43,411,146.62 | 32,215,012.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **590,403,845.61** | **612,213,015.95** |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 590,403,845.61 | 612,213,015.95 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 590,403,845.61 | 612,213,015.95 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **596,840,325.21** | **612,129,615.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **596,840,325.21** | **612,129,615.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 596,840,325.21 | 611,025,615.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 418,572,564.00 | 463,701,147.00 |
| 210101 | Үндсэн цалин | 418,572,564.00 | 463,701,147.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,575,211.63 | 55,671,678.33 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,224,012.63 | 37,544,284.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,137,524.00 | 6,426,983.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,935,099.00 | 2,413,211.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,027,233.00 | 1,857,440.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,251,343.00 | 7,429,759.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,094,434.56 | 11,281,933.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 856,934.56 | 1,576,933.41 |
| 210302 | Түлш, халаалт | 8,237,500.00 | 9,615,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 90,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,860,998.00 | 17,484,569.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,759,700.00 | 2,564,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,785,212.00 | 6,045,258.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,765,080.00 | 3,045,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 433,800.00 | 513,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,916,606.00 | 3,340,281.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 4,200,600.00 | 1,976,330.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 34,845,364.12 | 18,374,396.85 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 34,845,364.12 | 17,128,776.85 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 1,245,620.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,978,450.00 | 1,888,420.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,978,450.00 | 1,888,420.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 19,120,500.00 | 8,786,910.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,120,500.00 | 8,786,910.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,110,097.00 | 10,674,964.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,360,000.00 | 9,464,651.70 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 74,250.00 | 49,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,768.00 | 45,216.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 63,880.00 | 148,396.30 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 84,199.00 | 81,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,682,705.90 | 23,161,596.41 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 502,000.00 | 3,172,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,180,705.90 | 19,989,096.41 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 00.00 | 1,104,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 1,104,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,104,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **36,974,667.02** | **35,798,486.20** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **36,974,667.02** | **35,798,486.20** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **580,194,195.64** | **630,601,919.62** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **580,194,195.64** | **630,601,919.62** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 580,194,195.64 | 630,601,919.62 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 580,194,195.64 | 630,601,919.62 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **556,359,795.99** | **587,102,318.74** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **556,359,795.99** | **587,102,318.74** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **556,359,795.99** | **585,998,318.74** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 418,572,564.00 | 463,701,147.00 |
| 210101 | Үндсэн цалин | 418,572,564.00 | 463,701,147.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,575,211.63 | 55,671,678.33 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,224,012.63 | 37,544,284.71 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,137,524.00 | 6,426,983.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,935,099.00 | 2,413,211.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,027,233.00 | 1,857,440.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,251,343.00 | 7,429,759.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,394,434.56 | 15,231,933.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 856,934.56 | 1,576,933.41 |
| 210302 | Түлш, халаалт | 7,537,500.00 | 13,565,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 90,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,001,280.00 | 17,680,488.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,724,700.00 | 2,607,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,525,650.00 | 6,045,258.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,765,080.00 | 3,045,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 433,800.00 | 513,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,194,800.00 | 3,153,600.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,357,250.00 | 2,315,830.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 16,116,858.80 | 9,190,278.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,116,858.80 | 7,944,658.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 1,245,620.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,978,450.00 | 1,888,420.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,978,450.00 | 1,888,420.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 19,120,500.00 | 8,786,910.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,120,500.00 | 8,786,910.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,098,497.00 | 10,674,964.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,348,400.00 | 9,464,651.70 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 74,250.00 | 49,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,768.00 | 45,216.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 63,880.00 | 148,396.30 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 84,199.00 | 81,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 502,000.00 | 3,172,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 502,000.00 | 3,172,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **00.00** | **1,104,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 1,104,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,104,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **23,834,399.65** | **43,499,600.88** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,353,600.00** | **1,125,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,353,600.00** | **1,125,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,353,600.00 | 1,125,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,353,600.00 | 1,125,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-2,353,600.00** | **-1,125,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 21,480,799.65 | 42,374,600.88 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 26,451,203.85 | 47,932,003.50 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 47,932,003.50 | 90,306,604.38 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 35,108,550.00 | 18,042,888.28 | 122,007,982.46 | 175,159,420.74 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **35,108,550.00** | **18,042,888.28** | **122,007,982.46** | 175,159,420.74 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 36,974,667.02 | 36,974,667.02 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **35,108,550.00** | **18,042,888.28** | **158,982,649.48** | 212,134,087.76 |
| D01 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **35,108,550.00** | **18,042,888.28** | **158,982,649.48** | 212,134,087.76 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -5,531,216.80 | -5,531,216.80 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **35,108,550.00** | **18,042,888.28** | **153,451,432.68** | 206,602,870.96 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 35,798,486.20 | 35,798,486.20 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **35,108,550.00** | **18,042,888.28** | **189,249,918.88** | 242,401,357.16 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | Үзүүлэлт | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 601,204,143.60 | 588,227,318.74 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 601,204,143.60 | 588,227,318.74 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 600,004,143.60 | 587,123,318.74 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 471,680,700.00 | 463,701,147.00 |
| 210101 | Үндсэн цалин | 471,680,700.00 | 463,701,147.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 59,197,715.40 | 55,671,678.33 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,575,613.70 | 37,544,284.71 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 471,680.70 | 6,426,983.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,358,403.50 | 2,413,211.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,358,403.50 | 1,857,440.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,433,614.00 | 7,429,759.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 16,190,008.20 | 15,231,933.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,600,008.20 | 1,576,933.41 |
| 210302 | Түлш, халаалт | 14,500,000.00 | 13,565,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 90,000.00 | 90,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,055,000.00 | 17,680,488.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,885,000.00 | 2,607,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,100,000.00 | 6,045,258.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,050,000.00 | 3,045,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 520,000.00 | 513,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,100,000.00 | 3,153,600.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,400,000.00 | 2,315,830.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 8,000,000.00 | 9,190,278.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 8,000,000.00 | 7,944,658.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 1,245,620.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,000,000.00 | 3,013,420.00 |
| 210602 | Тавилга | 2,000,000.00 | 1,125,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,888,420.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,000,000.00 | 8,786,910.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,000,000.00 | 8,786,910.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,680,720.00 | 10,674,964.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,460,000.00 | 9,464,651.70 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | 864,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49,500.00 | 49,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 45,220.00 | 45,216.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 150,000.00 | 148,396.30 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 90,000.00 | 81,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3200000.00 | 3172500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,200,000.00 | 3,172,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1200000.00 | 1104000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,200,000.00 | 1,104,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,200,000.00 | 1,104,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 601,204,143.60 | 630,601,919.62 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 541,327,143.60 | 630,601,919.62 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 541,327,143.60 | 630,601,919.62 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 47,932,003.50 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 90,306,604.38 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 14.00 | 21.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 14.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 04.00 | 04.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар 213,651.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 64,183.4 мянган төгрөгийн алдааг залруулж 149,468.6 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж хүргүүллээ.

**3.1 Залруулсан алдаа:** Хөрөнгийн ашиглалтын хугацаа буруу бүртгэсэн 23,350.0 мянган төгрөг, хандиваар ирсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд зөв ангилж, бүртгээгүй 32,160.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа буруу бүртгэж, хөрөнгийн элэгдэл дутуу тооцоолсон 8,672.7 мянган төгрөгийн алдаа байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.", 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2 Төлбөрийн акт тогтоогоогүй.**

**3.3 Албан шаардлага хүргүүлээгүй.**

**3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## *1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал*

***<u>Илрүүлэлт:</u>*** Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тушаал байхгүй, тайлан, илтгэх хуудасгүй, холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлд Тооллогын комисс, түүний эрх, үүрэг , 72.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", 73 дугаар зүйлд "Эд хөрөнгийн тооллого явуулах журам" 73.1-т "Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж:</u>** Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хуульд заасны дагуу хагас болон бүтэн жилээр үнэн зөв, бодитоор хийж, холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлж хэвших;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитаар материаллаг зөрчил илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөрөнгийн ашиглалтын хугацаа буруу бүртгэсэн. | 1 | 23,350.0 | | | 1 | 23,350.0 | 1 | 23,350.0 | | | | |
| Хандиваар ирсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн тодруулга тайланд зөв ангилж, бүртгээгүй. | 1 | 32,160.6 | | | 1 | 32,160.6 | 1 | 32,160.6 | | | | |
| Үндсэн хөрөнгийн ашигла.тын хугацаа буруу бүртгэж, хөрөнгийн элэгдэл дутуу тооцоолсон. | 1 | 8,672.7 | | | 1 | 8,672.7 | 1 | 8,672.7 | | | | |
| **Дүн** | **3** | **64,183.4** | | | **3** | **64,183.4** | **3** | **64,183.4** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Зөвлөмж | | Албан шаардлага | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тооцоо бодоогүй, тайлан илтгэх хуудас байхгүй, холбогдох баримт материалын бүрдэл дутуу байна. | 1 | 149,468.6 | | | 1 | 149,468.6 | | | | | | |
| **Дүн** | **1** | **149,468.6** | | | **1** | **149,468.6** | | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА ОГНОО: 2026-02-22

**АНХАН ШАТАНД ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР ОГНОО: 2026-02-22

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2026-02-22

**БОЛОВСРУУЛСАН:**

СҮЛД АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2026-02-22